



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 28 өдөр

Дугаар A/131

Улаанбаатар хот


Г Дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын мэргэжилтэнд давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох, магадлан итгэмжлэх зөвлөлийн дүрэм”-ийг нэгдүгээр, зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох сургалт, давтан сургалтын үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Зөвлөлийн дарга (Б.Батцэцэг), Зөвлөлийн орлогч дарга шалгалтын комиссын дарга (Н.Чулуунбанди) нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 A/148 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, 2020 оны A/131 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
2023 оны //дүгээр сарын 28-ний өдрийн
119 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТЭНД
ДАВТАН СУРГАЛТ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ,
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ**

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ дүрмээр “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын мэргэжилтэнд давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох, магадлан итгэмжлэх зөвлөл” (цаашид “Зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. Зөвлөлийг салбарын төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр байгуулна.
- 1.3. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр нь мэргэшлийн зэрэг горилогчдын төлбөр, хандив тусламж болон бусад орлогоос бүрдэнэ.

ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.1. Зөвлөл нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.
- 2.2. Зөвлөлийн дарга нь Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, зөвлөлийн орлогч дарга нь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн захирал байна.
- 2.3. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон тус салбарт үйл ажиллагаа явуулж буй төр, хувийн хэвшлийн байгууллага, холбогдох их дээд сургуулийн төлөөллөөс бүрдэнэ.
- 2.4. Зөвлөл нь мэргэшлийн зэрэг олгох ажлыг удирдан зохион байгуулах, түүнтэй холбогдсон асуудлуудыг судалж, хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 2.5. Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байх бөгөөд асуудлыг хэлэлцэх, шийдвэр гаргах зарчмаар ажиллана. Зөвлөлийн дарга, орлогч дарга, гишүүд нь ижил саналын эрхтэйгээр хуралд оролцно.
- 2.6. Зөвлөлийн хурлын ирц нь 75 хувиас доошгүй байна. Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.
- 2.7. Зөвлөлийн шийдвэр нь хуралд оролцож буй гишүүдийн 75 ба түүнээс дээш хувийн санал авсан тохиолдолд хүчинтэйд тооцогдоно.
- 2.8. Зөвлөлийн шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд шийдвэрийг зөвлөлийн дарга баталгаажуулна.
- 2.9. Зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн шалгалтын зэрэг олгох шалгалтын комиссын шийдвэрийг хүчингүй болгох, шинээр томилох шалгалтыг дахин зохион байгуулах эрхтэй.
- 2.10. Зөвлөл нь мэргэшлийн зэрэг олгохтой холбогдсон асуудлаар өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, цаг хугацаанд нь шийдвэрлэнэ.
- 2.11. Зөвлөл нь сургалтын үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээлэл, шаардлагатай бусад баримт бичгийг мэргэжлийн зэрэг олгох шалгалтын комиссоор гаргуулан авах эрхтэй.

2.12.Зөвлөлийн гишүүнээс тодорхой асуудал хэлэлцүүлэхээр гаргасан саналыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

ГУРАВ.ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ОРЛОГЧ ДАРГА, ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХ

3.1.Зөвлөлийн дарга нь дараах эрх үүрэгтэй байна:

- 3.1.1.хуралдаанаар хэлэлцэх асуудлыг баталж, хуралдааны хугацааг товлох;
- 3.1.2.хуралдааныг удирдах;
- 3.1.3.зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулах;
- 3.1.3.зөвлөлийн шийдвэрийг баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих, гишүүдийн үүрэг оролцоо, хариуцлагыг дээшлүүлэх асуудлаар чиглэл өгөх;

3.2.Зөвлөлийн орлогч дарга дараах эрх, үүрэгтэй байна:

- 3.2.1.Зөвлөлийн даргаас өгсөн эрх хэмжээний хүрээнд холбогдох чиг үүргийг хэрэгжүүлэх;
- 3.2.2.тухайн салбарын тэргүүлэх мэргэжилтэн, их дээд сургуулийн профессор багш, эрдэмтдээс бүрдэх мэргэшлийн зэрэг олгох шалгалтын комиссын даргын чиг үүргийг хэрэгжүүлэх, комиссын бүрэлдэхүүнийг батлах;
- 3.2.3.сургалтын үйл ажиллагаа, менежментийг сайжруулахтай холбогдсон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, сургалтын төлөвлөгөөг батлах, үр дүнгийн тайланг хэлэлцэх;
- 3.2.4.мэргэжил дээшлүүлэх сургалтыг төлөвлөж, хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
- 3.2.5.сургалтын хөтөлбөрийг боловсруулж, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах;
- 3.2.6.сургалтын хөтөлбөр, агуулгатай уялдуулан сургалтын төлбөрийн жишиг хэмжээг тогтоох саналыг Зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлэх.

3.3.Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь:

- 3.3.1.хуралдааны товыг зарлах, зохион байгуулах, хуралдааны тэмдэглэлийг хөтөлж, зохион байгуулалтын ажлыг хариуцаж, хуралдааны тэмдэглэлд хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэр, санал хураалтын дүн, сонирхлын зөрчилтэй холбоотой тайлбар, шийдвэрийн талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбар зэргийг тэмдэглэнэ. Гишүүн тайлбараа бичгээр гаргаж болно.

3.3.Зөвлөлийн гишүүний эрх, үүрэг:

- 3.3.1.зөвлөлийн хуралдаанд биеэр, эсхүл цахим хэлбэрээр оролцох;
- 3.3.2.мэргэжлийн зэрэг олгох сургалт, шалгалтын бүх үе шатанд ашиг сонирхлын зөрчилгүй, хөндлөнгийн нөлөөгүй байх зарчмыг баримтлан хяналт тавьж оролцох;
- 3.3.3.холбогдох хууль, дүрэм, журмыг чанд баримтлан үнэнч, шударга, ёс зүйг эрхэмлэн ажиллах.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
2023 оны 11 дүгээр сарын 28-ийн өдрийн
11 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Б.Батцэцэг

(Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга)

Зөвлөлийн орлогч дарга, шалгалтын комиссын дарга:

Н.Чулуунбанди

(Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн захирал)

Гишүүд:

Х.Сүрэнхорол

(Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга)

Б.Билэгдэмбэрэл

(Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга)

С.Цагаанхүү

(Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга)

3.Эрдэнэчuluun

(Харилцаа холбооны зохицуулах хорооны Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга)

Т.Наранмандах

(Харилцаа холбооны зохицуулах хорооны хурлын нарийн бичгийн дарга)

Б.Дамдинсүрэн

(Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн профессор)

А.Эрдэнэбаатар

(Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн профессор)

Ч.Лодойравсал

(Монгол Улсын их сургууль, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн

профессор)

Л.Ариунаа
(Интек ХХК-ийн гүйцэтгэх захирал)

Ц.Болд
(Скайнэтвокс ХХК-ийн менежер)

Нарийн бичгийн дарга:

Д. Сэлэнгэ
(Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн)

Б.Энхтөгс
(ШУТИС, Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн Важпайн нэрэмжит сургалтын төвийн захирал)

Дээрээдээ

Боловсруулсан:	<i>Дээрээдээ</i>
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)	
Хянасан:	<i>Дээрээдээ</i>
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)	
Хувь:	<i>2</i>